

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 02 дүгээр сарын 23-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Туузан дамжуулагчийн сэлбэг нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2021-60**

**“ДЦС-4” ТӨХК** нь эрх бүхий тендерт оролцогчдоос Туузан дамжуулагчийн сэлбэг нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

**1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2019, 2020 он/

**2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

**3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:** Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онд ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

**Тендерийн хамт төсөвт өртгийн 2% үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.**

**Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.**

Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,**

**“ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө**

**Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс**

**7018-1309 7000-1357**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Т.ТӨМӨРХУЯГ